



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/39

Хархорин сум

Эзэмшил газрын зориулалт
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороолол 60 тоотод Хархорин сумын нэгдсэн эмнэлэгийн 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 6209007956 нэгж талбарын дугаартай 1187 м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Газар эзэмшигч Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Э.Дэнсмаа), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100077